

© The Financial Times Limited [2015]. All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

Британийн боловсролын хоцрогдол

Боловсролд шинэчлэл хийх томоохон оролдлогыг үл харгалзан Британийн сургуулиуд сайжирч чадаагүй гэнэ. > 10

Германд мусульман эмэгтэйн гивлүүрийг хориглоно

Сонгогчдыг татахын тулд мусульман эмэгтэйчүүдийг нүүрээ халхалсан гивлүүр зүүхийг хориглох санал дэвшүүлэв. > 10

Ерөнхийлөгчийн хэрэгт бизнесийн томчууд мэдүүлэг өгөв

Том группүүдийн удирдлага Ерөнхийлөгчид хандив өгсөн асуудлаар парламентын гишүүдийн өмнө тайлан тавьжээ. > 10

HPV вакцинаас үүдэлтэй зарга



HPV-ийн вакцины талаар Японы баримтлаж буй байр суурь бусад улсад ч нөлөөлж, Дани, Ирландад вакцинжуулалтын хэмжээ эрс багасчээ.

ВВМ©

Тэрбээр “Энэ эмчээс болж залуу эмэгтэйчүүд амь, амьдралыг нь аврах учиртай, аюулгүй, үр дүнтэй вакцин тариулахаа больсон. Үүнийг хариуцлагыг хүлээж чадах уу гэж Икеда эмчээс миний бие асуумаар байна” хэмээн өгүүлэв.

HPV-ийн вакцины талаар Японы баримтлаж буй байр суурь бусад улсад ч нөлөөлж, Дани, Ирландад вакцинжуулалтын хэмжээ эрс багасчээ. Улаанбурухан, гахайн хавдар, улаанууд өвчний (MMR) вакцинтай холбоотой түгшүүр 2000 оны эхээр үүсэж байсанчлан энэхүү вакцинаас болгоомжлох явдал ч дэлхий нийтийг хамарлаа.

Япон нь 2013 онд HPV-ийн вакцины үндэсний дархлаажуулалтын хөтөлбөртөө оруулжээ. Гэвч тарианаас шалтгаалсан хэмээн хохирогчид нь тайлбарлаж буй, мэдрэлийн

цочир гаж нөлөө харуулсан видео бичлэгийг зарга мэдүүлэгчид нийтлэсэнтэй уялдан вакцинжуулалтыг удалгүй зогсоосон байна. Мэдрэлийн гаж шинж тэмдэг HPV-ийн вакцинаас үүдэлтэй Японы Эрүүл мэндийн яам нотлож чадаагүй ч вакцинжуулалтыг дахин үргэлжлүүлэггүй юм.

Икеда эмч энэ оны эхээр хулгана дээр хийсэн туршилтад үндэслэн HPV-ийн вирус уураг тархины ажиллагаа хэвийн бус болох эмгэгтэй холбоотой гэсэн дүгнэлт хийсэн нь зарга үүсэх шалтгаан болжээ. Судалгааны дүгнэлт ташаа хэмээн Муранака эмч Японы сэтгүүлээр шүүмжилсэн. Икеда эмчийн судалгаа явуулсан Шиншюү их сургууль ч шалгалт явуулж, судалгааны өгөгдөл хуурамч биш болохыг тогтоолоо. Гэхдээ эмч ердөө ганц хулгана дээр туршсан өгөгдөлд тулгуурлан

дүгнэлт гаргах ёсгүй хэмээн тус их сургууль шүүмжилсэн юм.

Японы эрүүл мэндийн яам ч өнгөрсөн сард Икеда эмчийн дүгнэлтийг үгүйсгэсэн мэдэгдэл гаргаж, өвчтнүүдэд илэрсэн шинж тэмдэг нь HPV-ийн вакцинтай холбоотойг нотлох баримт байхгүй гэсэн тайлбар өглөө. “Икеда эмч зохисгүй мэдэгдэл гаргаж, олон нийтийг төөрөгдүүлэхэд хүргэснийхээ хариуцлагыг хүлээх ёстой” хэмээн тус яам мэдэгдэв.

HPV-ийн вакцин 2006 оноос хэрэглэнд нэвтэрсэн. Бэлгийн замаар тархдаг энэхүү вирус нь умайн хүзүүний хорт хавдрын бараг бүх тохиолдол болон бусад төрлийн өвчин эмгэгтэй ч холбоотой. Вакцинжуулж чадсансан бол сая эмэгтэй умайн хүзүүний хорт хавдар тусахгүй эрүүл байх байлаа хэмээн анагаах ухааны нэр хүндтэй мэргэжилтнүүд

халаглаж харамссаар. Олон мянган өвчтөн хамарсан өргөн цар хүрээтэй судалгааны явцад уг вакцин аюултайг нотлох баримт илрээгүйг эрдэмтэд онцлон дурддаг.

Зарга мэдүүлэгч Икеда эмч шинжлэх ухааны маргааныг шүүхийн танхимд шилжүүлсэн нь зохисгүй хэрэг хэмээн Муранака эмч тайлбарлав. Ийм зарга цаашид эмч нар HPV-ийн вакцины талаар ярихаас эмээхэд хүргэх аюултайг тэрбээр анхааруулсан юм.

Харин Икеда эмчийн өмгөөлөгч Цүтому Шимизү “Зарга нь шинжлэх ухааны маргаан бус” хэмээн үзлээ. Тэрбээр шүүхийн зарга нь вакцинтай холбоотой шинжлэх ухааны маргаан бус, Муранака эмчийг хуурамч дүгнэлт хийсэн гэж буруутгасантай холбоотой хэмээн тайлбарлаж байна.

FT

Трамп Boeing-той байгуулсан гэрээг шүүмжлэв

Деметри Севастопуло

Дональд Трамп хэтэрхий үнэтэй гэсэн шалтгаанаар АНУ-ын Ерөнхийлөгчийн унаа Air Force One онгоц бүтээхээр Boeing-той байгуулсан гэрээг цуцлахыг уриаллаа. Уг уриалга Ерөнхийлөгчөөр сонгогдогч байр сууриа ашиглан америкийн компаниудыг дарамтлаж буйн шинэ жишээ болов.

“Boeing компани ирээдүйн Ерөнхийлөгч нарт зориулан цоо шинэ 747 Air Force One бүтээж байгаа нь тэнгэрт хадсан үнэтэй юм. Захиалгыг цуцла!” хэмээн ноён Трамп мягмар гарагт твиттертээ бичжээ.

Boeing компани АНУ-ын Ерөнхийлөгч нарт олон арван жил үйлчилж ирсэн одоогийн Air Force One-ийн паркийг орлох хоёр 747 бүтээж байгаа юм. Холбоо харилцааны цогц тоног төхөөрөмж бүхий АНУ-ын Ерөнхийлөгчийн хөлөг хувийн унаанаас ялгаатай ч ноён Трамп одоогоор “Trump Force One” гэгдэх болсон хувийн онгоцоо хэрэглэж байгаа.

Ерөнхийлөгчийн алба шилжүүлэх бэлтгэл хариуцсан багийнхан байрлаж буй Трамп Тауэрт цугласан сэтгүүлчдэд

747 онгоцны үйлдвэрлэлийг хэвээр үргэлжлүүлэхэд чухал ач холбогдолтой.

Ноён Трамп, дэд ерөнхийлөгчөөр сонгогдсон Майк Пенс нар саяхан Индиана муж улсын сэрүүцүүлэх төхөөрөмж үйлдвэрлэгч Carrier компанийг 1000 ажлын байраа Мексикт шилжүүлэх төлөвлөгөөнөөс нь татгалзуулж дөнгөсний дараа дээрх тайлбар гарч байна. Индиана муж улс Carrier компанид долоон сая ам.доллар хүртэлх татварын хөнгөлөлт үзүүлэх замаар асуудлыг шийдвэрлэсэн нь Трампыг дэмжигчдээс талархал хүлээсэн. Politico/Morning Consult-ын санал асуулгын дүнгээс үзвэл Carrier-тэй холбоотой шийдвэр АНУ-ын сонгогчдын 60 хувьд нь ноён Трампыг сайнаар үнэлэх шалтгаан болжээ. Харин 2008 онд Бүгд найрамдах намаас дэд ерөнхийлөгчид нэр дэвшиж байсан Сара Палин зэрэг хүмүүс уг арга хэмжээг шүүмжлэв. Ноён Пенс Индиана муж улсын захирагч учраас л гаргаж чадсан дээрх шийдвэр нь эдийн засгийн талаасаа явцгүй хэмээн шүүмжлэгчид тайлбарлаж байна.



тэрбээр дээрх наймааны үнийг “Хөгийн” хэмээн тайлбарлав. Гэхдээ дөрвөн тэрбум ам.долларын үнийг хаанаас гаргасан, ямар үндэслэлээр үнэ хэт өндөр гэж үзсэнээ тайлбарласангүй. “Boeing тоогоор тоглоод байна. Boeing-д мөнгө орохыг бид дэмждэг ч ийм их байж арай ч болохгүй” хэмээн ноён Трамп өгүүллээ.

Boeing компани твиттерийн бичлэгт шууд хариу өгсөнгүй. Гэхдээ тус компани Ерөнхийлөгчийн тусгай шаардлагад нийцсэн, цэргийн зориулалт бүхий хоёр онгоцны чадварыг тодорхойлох ажилд зориулан 170 сая ам.долларын гэрээ байгуулахаар ид хэлэлцэж байгааг мэдэгдэв.

Чикагод байрладаг тус компани: “Ерөнхийлөгчид зориулсан шилдэг хөлгийг татвар төлөгчдөд үнэмлэхүй ашигтайгаар бүтээх хөтөлбөрийн хожмын үе шатанд ч АНУ-ын Агаарын цэргийн хүчтэй хамтран ажиллана хэмээн найдаж байгаа”-гаа тайлбарласан юм.

Үнэ, зардалтай холбоотой маргаан үүсэх үндэслэлгүй хэмээн Teal Group-ын шинжээч Ричард Абулафия үзэж байна. “Цаадах чинь аманд орсноо л дуугарах юм. Энэ хүний үгээр л үнэ зардлын асуудал босно гэж байхгүй. Дүгнэлт хийхэд дэндүү хатуу байгаа” хэмээн шинжээч өгүүллээ.

АНУ-ын Агаарын цэргийн хүчинтэй байгуулдаг Air Force One буюу Ерөнхийлөгчийн нисэх онгоц бүтээх гэрээ нь 1970 оноос хойш ашиглаж буй Boeing

FT

Европын компаниудад дарамттай хяналт

Чарльз Кловвер

Валютын гүйлгээнд тавьж буй нарийн хяналтаас шалтгаалан Хятад дахь Европын хэд хэдэн компани ноогдол ашгаа гүйвүүлж чадсангүй. Энэ нь хөрөнгө гадагш урсан гарах явдлыг багасгах БНХАУ-ын эрх баригчдын чармайлт гадаадын компаниудын бизнест хүндрэл учруулж эхэлсний анхны шинж тэмдэг хэмээн шинжээчид тайлбарлаж байна.

Европын компаниудад тохиолдсон төлбөрийн бэрхшээл нь “Бизнесийн үйл ажиллагаанд уршиг тарьж байгаа”-г Бээжин дэх Европын холбооны Худалдааны танхим анхааруулав. Мөнгө гадагш гуйвуулахад баримтлах ёстой нарийн түвэгтэй цогц журмыг Хятад улс арваннэгдүгээр сарын 28-наас мөрдөж эхэллээ.

Энэ онд тус улсаас гадагш урсах хөрөнгийн хэмжээ урьд тохиолдож байгаагүй зүйл ам.доллартай харьцах юанийн ханш бараг зургаан хувиар уналаа. Юанийн ханш уналт энэ онд үнэмлэхүй сөрөг амжилт тогтоох гэж байгаагаас Хятад улс валютын нөөцөө хадгалж үлдэхээр чармайлт байна.

Тус улс валютын нөөц ам.доллараа зарах замаар юанийн ханшийг тогтоон

барихаар оролддог. БНХАУ-ын валютын нөөц багассаар энэ оны аравдугаар сард 3.12 их наяд ам.доллар болсон нь 2012 оны гуравдугаар сараас хойш тохиолдоогүй үзүүлэлт юм. Шанхайд байрладаг компани даваа гарагт хэдэн зуун сая юанийн ноогдол ашгаа шилжүүлж чадалгүй гацлаа. Өмнөд Хятадын өөр нэг хотод ажилладаг Европын компани өнгөрсөн долоо хоногт 900 сая юань буюу 131 сая ам.долларын төлбөр хийж гэсэн ч зөвшөөрөл олгоход хугацаа хэрэгтэй хэмээн хүлээлгэжээ. Баруун өмнөд Хятадад байрладаг, хоёр тэрбум юанийн ноогдол ашиг гуйвуулах гэсэн өөр нэг компани төлбөрийн нарийн төлөвлөгөө гаргаж өг гэсэн шаардлагатай тулгарсан байна.

Хятад дахь Европын холбооны худалдааны танхим уг шаардлагыг урьд өмнө тохиолдож байгаагүй зүйл хэмээн тайлбарлав. Шанхайд байрладаг, БНХАУ-ын зохицуулах байгууллага - Валютын хэрэг эрхэлсэн төрийн хороо (SAFE) өнгөрсөн долоо хоногт хуралдаж, гадаад, дотоодын 20 банкнд нэн даруй эргэжүүлэх ёстой, валютын урсгах зохицуулах “Цонхны удирдамж”-ийг тайлбарласан заавар өгсөн нь



бэрхшээл үүсгэлээ.

Шинэ журмаар компаниуд зээлийн эргэн төлөлт, ноогдол ашиг хуваарилалт зэрэгтэй холбоотойгоор таван сая ам.доллараас их хэмжээтэй валют гадагш гуйвуулах тохиолдолд Валютын хэрэг эрхэлсэн төрийн хорооноос зөвшөөрөл авах ёстой. “Хөрөнгийн гадагш урсгалд хяналт тавих зорилго бүхий ил нийтлээгүй шинэ удирдамж нь Европын холбооны танхимын тэргүүн Йорг Вуттке мэдэгдлээ. Тэрбээр уг удирдамж Хятадын хөрөнгө оруулалтын орчныг урьдчилан тооцоолох аргагүй болгож байгааг давхар анхааруулав.

Зарим банк үйлчлүүлэгчдэдээ

валют гадагш гуйвуулах тухай 10 хуудас өргөдлийн маягт бөглөхийг зөвлөдөг. Уг маягтыг Валютын хэрэг эрхэлсэн төрийн хороо тав хоногт багтаан хэлэлцэж, зөвшөөрөл олгох, эсэхээ хариу мэдэгдэж байна.

Хятад дахь Европын холбооны банкуудын хувьд “Ийм маягт бөглүүлэх хувилбар байгаа ч зөвшөөрөл авч чадах магадлал тун муу. Урьд нь зүгээр болоод байсан ноогдол ашиг гуйвуулах ажиллагаа хүлээгддэг болчихлоо” хэмээн Худалдааны танхим тайлбарлав.

Шинэ журам хот бүрт адилгүй байгааг Европын холбооны Худалдааны танхим дурдлаа. Зөвшөөрөл авах ёстой хэмжээ зарим хотод таван сая ам.доллараас ч бага, жишээ нь Чунчинд нэг сая байгаа юм.

FT

© The Financial Times Limited (2015). All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

Хелен Уоррел

Боловсролд шинэчлэл хийх томоохон оролдлогыг үл харгалзан Британийн сургуулиуд сайжирч чадаагүй гэнэ. Олон улсын үзүүлэлтээс харахад Британийн сурагчид Сингапур, Финланд, Эстонийн хүүхдүүдийн ард бичигджээ. Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас (OECD) гаргадаг Pisa үнэлгээгээр 70 орны 15 настай хагас сая сурагчийн дунд тест явуулж дүнг жагсаадаг. Саяын жагсаалтын байдал гурван жилийн өмнөхөөс бараг өөрчлөгдөөгүй ба Азийн эдийн засгууд тэргүүлж, Их Британи хуучин байрандаа үлджээ.

Жагсаалтын тэргүүнд уншлага, математик, шинжлэх ухаан гэсэн гурван үзүүлэлтээр Сингапур Шанхайг ухраан гарч ирэв. Pisa үнэлгээнд Хятадын Бээжин, Жиансу, Гуандон мужуудыг хамруулах болсноор Шанхайн математикийн үзүүлэлт доошилсон байна. Британийн хувьд шинжлэх ухаанаар 21-ээс 15 дугаар байр руу дээшилсэн бол математикаар нэг шат ухарч 27-д, уншлагаар нэг байр ахиж 22-т бичигдлээ. Их Британи дотроо гурван хичээлээр Англи тэргүүлж, Уэльс, Шотланд хоёр хойш нь чангаажээ.

Тус улсад боловсролын түвшинг дээшлүүлэх арга хэмжээ авсан хэдий ч үр дүн иймэрхүү байна. Сүүлийн Засгийн газар Англид шалгалт, хичээлийн хуваарь, сургуулийн бүтцэд шинэчлэл явуулсан. Тухайн үед Боловсролын сайд Ники Морган “2020 он гэхэд Англи дэлхийд эхний тавд багтаж, Европт англи хэл, математикийн хичээлээр тэргүүлнэ” гэж зарлаж байв. Шотландад түүнчлэн эрх баригч Үндэсний нам тодорхой өөрчлөлт хийж, сургуулийн захирлуудын эрх мэдлийг өргөтгөнө гэж амалсан.

Гэвч Pisa үнэлгээнээс үзэхэд хэмнэлтийн он жилүүд

Британийн аж үйлдвэрийн холбоо сурагчдын ерөнхий амжилт бизнесийн асуудал болж магадгүйг анхааруулав.



Британийн боловсролын хоцрогдол

шинэчлэл ахихгүй байгаагийн шалтгаан биш бололтой. Британи 6-15 насны нэг сурагчид 114900 ам.доллар зарцуулдаг нь OECD-ийн дундаж 90300 ам.доллартай харьцуулахад нэлээд өндөр байна. Английн сургуулийн стандартын сайд Ник Глибб “Бид бүх залууст чадвараа ашиглах боломж өгөхийн тулд дэлхийн зэрэглэлтэй боловсрол олгох шийдвэр төгс байгаа” хэмээжээ. “Тэгш боловсролын холбоо” байгууллага дээрх дүнг Британийн хувьд сэрэх дохио боллоо гээд боловсролын тэгш бус байдал ба орлогын хоорондын хамаарал энд Канад, Эстони улсаас дээгүүр байгааг

онцолжээ. Боловсролын холбооны нийгэмлэгийн тэргүүн Ричард Ламберт “Хэрэв бид чадварын ялгааг арилгахын тулд түргэн хөдлөхгүй бол дараагийн 10, 20 жилд ард хоцорсон арал болон хувирч, дэлхий хажуугаар өнгөрөхийг ажиглаж суух болно” хэмээн өгүүлэв. OECD-ийн боловсрол, чадвар хариуцсан захирал Андреас Шлейхер Британийн дүнг тайлбарлан ярихдаа Ерөнхий сайдын санал болгосон бага сургуулийн тоог нэмэгдүүлэх төлөвлөгөөнийг хүрээнд хүүхдийг сонгож элсүүлэхээс зайлсхийхийг анхааруулсан байна. Тэрбээр “Pisa

судалгаанаас үзэхэд хичээлийн амжилтаар шалгаруулдаг байдал нэмэгдэх тусам нийгмийн ялгарал явагддаг нь батлагдсан зүйл. Сурагчдын амжилт ба нийгмийн байдал хоёр нягт холбоотой. Үүний нотолгоо илэрхий харагддаг” хэмээв.

Teach First хэмээх багш элсүүлэх байгууллагын захирал Бретт Вигдорц 10 хичээлээр эхний аравт багтсан Канадын үзүүлэлтийг эш татан, Их Британийн хувьд дуурайл болох жишээ мөн гэжээ. Тэрбээр сайн сургалттай Сингапур, Япон, Өмнөд Солонгос зэрэг Азийн орнуудын заах арга нь Британи, Канадынхаас

ялгаатайг тэмдэглээд “Сүүлийн хоёр улс төстэй учир туршлага солилцох боломжтой” гэж дүгнэсэн байна. Ноён Вигдорц цааш нь “Канадчууд гэрлийн жилээр урагшаа явчихлаа. Тэд сургуулиудын хамтын ажиллагааг үнэхээр сайн зохицуулж чадсан байна. Багш нарт мэргэжлээрээ ахихад нь сайн тусалдаг. Түүнчлэн хоцрогдсон сурагчдыг ард орхидоггүй. Канад наад захын стандартыг хангах тал дээр сайн ажлаж байна” хэмээв. Британийн аж үйлдвэрийн холбоо сурагчдын ерөнхий амжилт бизнесийн асуудал болж магадгүйг анхааруулав. Тус холбооны ажиллах хүч,

чадамжийн бодлогын захирал Нил Карберри “Сүүлийн үнэлгээ бидний сэтгэлийг түгшээж байна. Судалгаанаас үзэхэд эдийн засгийн өсөлтийн үндсэн хөдөлгөгч хүч нь боловсрол юм” гэжээ. Тэрбээр “Саяын дүнд өгөх хамгийн үр ашигтай хариулт нь математик, уншлага, шинжлэх ухааны хичээлүүдэд төвлөрч, хамгийн сайн арга барилыг хэрэгжүүлэх явдал. Дээд зэрэглэлийн удирдагчид хичээлийн хуваарь сонголтод оролцон, залуусыг амжилтад хүргэх үндсэн чадамж, хандлага, зан чанар бий болгоход анхаарах ёстой” хэмээн өгүүлсэн юм.

Ерөнхийлөгчийн хэрэгт бизнесийн томчууд мэдүүлэг өгөв

Брайан Харрис

Өмнөд Солонгосын том группүүдийн удирдлага Ерөнхийлөгчид хандив өгсөн асуудлаар парламентын гишүүдийн өмнө тайлан тавьжээ. Ерөнхийлөгчийг огцруулж болзошгүй авлигын хэрэгт тэд ямар үүрэг гүйцэтгэсэн талаар гишүүд асууж, байцаасан байна. Тус улсын хамгийн хүчирхэг хүмүүс болох Samsung-ийн

авсан хэрэг өнгөрсөн сард илэрсэн билээ. Чой удган Ерөнхийлөгчийн бодлогын асуудлаас эхлээд юу өмсөж зүүхэд нь хүртэл оролцон нөлөөгөө ашиглаж байсан тухай яригдаж байгаа. Уг дуулианы улмаас эсэргүүцлийн хөдөлгөөн өрнөж, сүүлийн өдрүүдэд жагсаал, цуглаан тасарсангүй.

Мягмар гарагт мэдүүлэг өгсөн нэг бизнесмен хатагтай Чойд

оролцсон нээлттэй асуулга Өмнөд Солонгост нэн ховор тохиолддог зүйл. Тэдний сур нөлөө нийгэмд асар хүчтэй бөгөөд авлига, татвараас зугтсан хэрэгт байнга холбогддог авч төдөлгүй “сайн санааг” Засгийн газрын ачаар өршөөгддөг уламжлалтай.

Парламентын мөрдөн байцаалтын үндсэн хэсэг нь ноён Ли дээр төвлөрч, хандив



Германд мусульман эмэгтэйн гивлүүрийг хориглоно

Стефан Вагстил

Германы канцлер Ангела Меркель ирэх онд болох сонгуулийн өмнө сонгогчдыг татахын тулд мусульман эмэгтэйчүүдийг нүүрээ бүрэн халхалсан гивлүүр зүүхийг хориглох санал дэвшүүлэв. Энэ нь өнгөрсөн онд дүрвэгсдэд хаалгаа дэлгэх бодлого явуулсан талаар шүүмжлэлээс зайлсхийж, цагаачдыг нийгэмшүүлэх арга хэмжээгээ чангатгах зорилготой аж. Канцлер Христийн ардчилсан намын бага хурал дээр “Бидний журам бол нүүрээ ил байлгах явдал. Иймээс гивлүүр зохимжгүй зүйл. Үүнийг хуулийн хувьд боломжтой бүх газарт хориглох ёстой” хэмээн мэдэгдсэнийг алга ташин хүлээн авлаа.

Хатагтай Меркель түүнчлэн өөрийнх нь намд халтай популист хүчин, тухайлбал цагаачлалыг эсэргүүцдэг Германы алтернатив намыг сөрөн зогсохыг хичээж байна. Тэрбээр дөрөв дэх удаагаа сонгогдохын тулд Христийн ардчилсан нам дотроос бүрэн дэмжлэг авахыг эрмэлзэж байгаа юм. Канцлер хэлсэн үгэндээ

ХАН-ын Бавари муж дахь илүү консерватив жигүүр болох Христийн нийгмийн холбоонд хандан албан ёсоор батламж авах талаар ярьсан байна. Уг бага хурлаар намын даргыг сонгох санал хураалт явуулахад Меркель 89.5 хувиар яллаа. Хоёр жилийн тэртээ дүрвэгсдийн хямралаас өмнө түүний дэмжлэг 96.8 хувьтай байснаас буурсан боловч харьцангуй дээгүүр санал авлаа гэж албаныхан тэмдэглэв. Бундестагийн Европын холбоотой харилцах хорооны дарга Гюнтер Кришбаум Financial Times сонинд ярихдаа “Бараг 90 хувийн санал авна гэдэг бол амжилт. Ялангуяа Социал демократ намын дарга Зигмар Габриель 74 хувийн дэмжлэгээр дахин сонгогдсонтой харьцуулахад бүр ч тийм” хэмээсэн юм.

Меркель аж үйлдвэрийн Эссен хотод хэлсэн үгэндээ 2015 оны дүрвэгсдийн хямралыг дахин давтахгүйгээ амлав. Тухайн үед Герман руу сар бүр хэдэн арван мянган цагаач цувж байсан билээ. Канцлер “Тэр байдал давтагдаж болохгүй, давтагдах ёсгүй” гэж шүүхийн танхим

зэрэг улсын байранд гивлүүрийг хориглохыг уриалсан юм. Хэдийгээр Германд исламын шашинт цөөн мянган эмэгтэй гивлүүр зүүдэг авч хуучинсаг үзэлтнүүд үүнийг нийгэмшихээс татгалзаж буйн илрэл гэж үздэг аж.

Хатагтай Меркеллийн санаачилгыг намын гишүүдээс нь олон хүн талархан дэмжсэн байна. Ноён Кришбаум “Үүнийг түүний өөрийнх нь амнаас тодорхой сонсоход таатай байлаа. Бид Германд бүтэн гивлүүрийг хориглох ёстой. Учир нь гивлүүр бол нийгэмшихэд учирдаг саад



ерөнхийлөгчийг залгамжлагч Жэй И Ли, Hyundai Motors-ын захирал Чун Мон Ку зэрэг томчууд парламентын мөрдөн байцаалтад ирж, Ерөнхийлөгчийн туслахуудад олон сая ам.долларын хандив өргөөд, ашиг хүртсэн, эсэх талаараа ярихад хүрвэ. Асуулт, хариултыг телевизээр шууд дамжуулсан нь бүр ч их дуулиан тариллаа.

Өмнөд Солонгосын анхны эмэгтэй Ерөнхийлөгч Пак Гын Хэ ирэх долоо хоногт болох үл итгэх асуудлаар санал асуулгыг давж чадвал дөрөвдүгээр сард огцрох ёстойг Уг мөрдөн байцаалт сануулах зорилготой аж. Ерөнхийлөгчийн итгэмжит хүн Чой Сун Ил болон хэд хэдэн туслах нь том компаниудаас 65 сая гаруй ам.доллар шаардаж

хандивын мөнгө өгснөө хүлээсэн боловч Ерөнхийлөгчөөс хариу тус хүртээгүй гэжээ. Samsung Electronics-ийн дэд захирал, үнэн хэрэгтээ бүх группийг хариуцдаг ноён Ли “Ерөнхийлөгч Пак бидэнд хандан спорт, урлаг, жуулчлалыг өгөөрөөр дэмжихийг уриалсан. Гэхдээ бид хариу тус хүсээгүй” хэмээн өгүүлэв.

Солонгосын аж үйлдвэрийн холбооны тэргүүн Ху Чан Су хатагтай Чой болон бизнесийн хооронд зуучлагчийн үүрэг гүйцэтгэсэн агаад “Бизнесийн удирдлагын үүднээс харахад Засгийн газрын хүсэлтийг үл ойшоход бэрх. Нянгуяа, Өмнөд Солонгосын илтгэмд бүр ч боломжгүй” хэмээв. Корпорацийн томчууд

Корпорацийн томчууд оролцсон нээлттэй асуулга Өмнөд Солонгост нэн ховор тохиолддог зүйл.

өгөөд, хариуд нь Samsung компанийн хоёр салбарыг нэгтгэх маргаантай үйл ажиллагаанд дэмжлэг авсан, эсэхийг нягтлах зорилготой байв. Ноён Ли нэгтгэх ажиллагаа түүний залгамжлах үйл явцтай холбоотой гэх нотолгоог няцаав. Үүний зэрэгцээ Өмнөд Солонгосын 5000 иргэн Ерөнхийлөгч Пак Гын Хэгийн эсрэг зарга үүсгэж, шуугиан дуулианы улмаас учирсан сэтгэл санааны хохиролдоо 400 ам.доллар нэхэмжилжээ. Тэдний өмгөөлөгч Yonhap агентлагт ярихдаа “Ерөнхийлөгч өөрийн албан тушаалыг ашиглан гэмт үйлдэл хийсэндээ хариуцлага хүлээх ёстой” гэж мэдэгдсэн юм.

FT

FT